Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн
А/588 тоот албан бичгийн 2 дугаар хавсралт

2022 ОНД “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛ”-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилго	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Газрын харилцааны салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.			
Үр дүн	1.1. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангасан байна. 1.2. Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогын хэрэгжилтийн талаарх мэдлэг, арга замын талаарх ойлгоцыг бүх түвшинд түгээсэн байна. 1.3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд болон иргэнийг ажилд авахад нас, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, газрын байршил болон бусад зүйлээр үл ялгаварлах, ажлын байранд бэлгийн дарамт шахалт үүсэхгүй байх зохицуулалт, нөхцөл бүрдэнэ.			
Зорилт	1.Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах; 2.Салбарын ажилтнуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаагаар мэдлэг, судалгаа, мэдээлэлд суурилан хэрэгжүүлэх.			

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх Байгууллага
Зорилт 1: *Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, Жендэрийн үндэсний хорооноос гарсан шийдвэр, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах.*				
1.1. Жендэрийн тэгш байдлыг хангах, Газрын харилцааны салбарт Жендэрийн талаар	1.Газрын харилцааны салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга замын талаар	ШҮ1: Хэлэлцүүлэг-1; ШҮ2: Хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авч	1. Агентлаг: “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, БХБЯ-ны дэргэдэх Жендэрийн орон тооны бус зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд lkhamserjid@yahoo.com хаягаар санал өгсөн. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах 2022 оны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан.	

баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлд төр, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.	хэлэлцүүлэг зөвлөгөөнд хамрагдсан байна.	хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн; ШҮЗ: Сургалт, сурталчилгааны ажлын тоо.	Батлагдсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн ГЗБА-нд тус газрын даргын 2022.02.18-ны өдрийн 1/294 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг нэгтгэн авсан. Албан хаагчдын хүйсийн судалгааг эрэгтэй, эмэгтэйг хэлтэс тус бүрээр гаргалаа. Агентлагийн албан хаагчдыг төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчдаар ангилан, хүйсийн судалгааг хэлтэс тус бүрээр тус газрын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ, мөн тус газрын дэргэдэх Жендэрийн орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүний дэлгэрэнгүй судалгааг гарган хүргүүлсэн. "НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЪЯ" уриан дор Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэж, 21 аймгийн ГХБХБГ-ын бүрэн хамруулсан. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, түүний биелэлтэд хяналт тавих, үр дүнг хэлэлцэх, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх сургалтад 2022.12.01-ний өдөр хамрагдсан. Жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх болон ажлын байрны бэлгийн дарамт, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалтуудаас дурьдвал: a) Салбарын "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ий төлөвлөгөөнд тусган ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлаар Удирдлагын академийн багшийг урьж лекц уншуулсан. b) Төв аймгийн ГХБХБГ-аас 2022.03.09-11-ний өдөр зохион байгуулсан сумын Газрын даамлуудад зориулсан сургалтад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр, c) Өмнөговь, Увс, Завхан, Сүхбаатар аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулсан сумын Газрын даамлуудад зориулсан сургалтад Ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Мөнхзул "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр цахимаар илтгэл тавьж оролцсон. d) Канадын Засгийн газрын санхүүжилтээр "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь" Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр төслийн багтай байгууллагын ёс зүйн зөвлөл хамтран төрийн байгууллагын үр дүнг дэмжих хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ёсзүйн сургалтыг 2022.09.23-ны өдрийн 08.30-10.30 цагийн хооронд зохион байгуулж, нийт 56 албан хаагч хамрагдсан e) Архангай аймгийн ГХБХБГ-ын албан хаагч, сумдын газрын даамлууд нийт 40 албан хаагч сургалтад /zoom/ хамрагдсан. f) Нийт албан хаагчдын хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах тохиолдол бүрд Ёс зүйн зөвлөлийн дарга санамж, зөвлөгөө өгч ажиллаж хэвшсэн.

			2. Орхон аймгийн ГХБХБГ: "Жендэрийн мэдрэмжтэй газар зохион байгуулалт" сэдэвт ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан сургалтад Суурь судалгаа мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Эрдэнэзул хамрагдсан. 3. Сүхбаатар аймгийн ГХБХБГ: Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөн нь барилга, хот байгуулалтын салбарын "Цахим шилжилт-2022", "Газрын харилцааны салбар дундын олон талын оролцоог хангах, хамтын уялдааг сайжруулах нь" гэсэн 2 дэд хэсэгт хуваагдан нийт 250 гаруй хүний бүрэлдэхүүнтэй зөвлөгөөн болсон. Энэхүү зөвлөгөөн дээр Жендэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, энэ чиглэлд төр, мэргэжлийн байгууллагуудтай санал солилцож хамтран ажиллах талаар зөвлөлдсөн. НҮБ-ын ХХААБ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас хамтран хэрэгжүүлж буй Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төслөөс аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан салбар дундын ажлын хэсэг болон газрын хэлтсийн мэргэжилтнүүд, сумдын газрын даамлууд зэрэг нийт 34 албан хаагч "Газар зохион байгуулалтыг жендэрийн мэдрэмжтэй хэрхэн төлөвлөх" сэдэвт сургалтад хамрагдсан. 4. Баянхонгор аймгийн ГХБХБГ: Жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд "Жендерийн мэдрэмжтэй удирдагч" 5 албан хаагчдыг хамруулж оролцсон. 5. Говь-Алтай аймгийн хэмжээнд 2022.05.18-ны өдрүүдэд Хүний эрхийн Үндэсний комиссоос Монгол улсад мэргэшсэн төрийн албыг бий болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулах, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын шинээр баталсан хууль хэрэглээ ба жендэр, хүний эрхийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж буй сургалтад Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөл хариуцсан мэргэжилтэн Ш.Батчимэг хамрагдсан. 6. Төв аймгийн ГХБХБГ: Хүний эрхийн хорооны салбар зөвлөлийн дарга Чойжилсүрэн, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Лхагвасүрэн нартай хамтран "Хүний эрхийн талаар баримтлах бодлого", "Жендэрийн тэгш байдал", "Жендерийн талаар баримтлах бодлого" талаар сургалтыг 3 дугаар сард албан хаагчдад сургалт явуулсан. 7. Дундговь аймгийн ГХБХБГ: Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг "Хүний эрхийн үндсэн ойлголт", "Жендэрийн эрх тэгш байдал" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн сумдын Газрын даамлуудын сургалтын үеэр дээрх сургалтыг дахин зохион байгуулсан. Нийт 2 удаагийн сургалтад нийт 28 албан хаагч хамрагдсан.
1.2. Газрын нэгдмэл сангийн	1. Газрын нэгдмэл сан болон	ШҮ1: Мэдээлэлд	Улсын хэмжээнд 598232 иргэн газар өмчилсөн байгаагаас эмэгтэй 271157 иргэн нийт 25699,6 га газар, эрэгтэй 327075 иргэн нийт 33135,6 га газар тус тус өмчилсөн байна.

улсын нэгдсэн тайланд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын талаарх мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргаж, мэдээллийг бүрдүүлэх.	салбарын хүний нөөцийн мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргадаг болсон байна. 2. Салбарын үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөхөд суурь судалгаатай болсон байна.	хамрагдалтын тоо; ШҮ2: Хэрэгжилтийн хувь	Улсын хэмжээнд 542052 иргэн газар эзэмшиж байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 212203 иргэн нийт 74053,4 га газар, эрэгтэй 261278 иргэн нийт 335331,9 га газрыг тус тус эзэмшиж байна.   

			1. Орхон аймгийн ГХБХБГ: Газрын удирдлагын кадастрын цахим системд МУ хэмжээнд иргэний бүртгэлээр МУ эрх зүйн чадамжтай иргэн-1130883, МУ эрх зүйн чадамжгүй иргэн-41217, МУ хуулийн этгээд-22530, МУ төрийн байгууламж-4664, Гадаадын иргэн-159, Гадаадын хуулийн этгээд-512, Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд-222, СӨХ-314, Чөлөөт бүс-121 байна. Орхон аймгийн хэмжээнд газар өмчлөгч-20808, гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглагч-6311 байна. 2. Хөвсгөл аймгийн Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайланд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын талаарх мэдээллийг нас, хүйсээр ангилан гаргаж, мэдээллийг бүрдүүлдэггүй бөгөөд газрын нэгдмэл сангийн ангиллын журмын дагуу тайланг гаргаж байгаа. 2022 оны хагас жилийн байдлаар тус газарт 45 албан хаагч /газрын даамал, мэргэжилтэн, төрийн үйлчилгээний албан хаагчид/ ажиллаж байгаагаас 21 эрэгтэй 24 эмэгтэй албан хаагч байна. 3. Говь-Алтай аймгийн хэмжээнд газар өмчилсөн 7911 иргэн байгаагаас 5288 эрэгтэй, 2623 эмэгтэй байгаа нь нийт хүн амын 13.6%, эзэмшил 10497 иргэн байгаагаас 9344 эрэгтэй, 1064 эмэгтэй байгаа нь нийт хүн амын 18 хувийг эзэлж байна. 4. Ховд аймгийн ГХБХБГ: Газрын нэгдмэл сангийн аймгийн нэгдсэн тайлангаас газар өмчлөгч, эзэмшигчийн мэдээллийг хүйсээр ангилан гаргахад нийт 20213 өмчлөгчийн 62 хувь нь эрэгтэй, 38 хувь нь эмэгтэй байна. Харин нийт 17567 эзэмшигчийн 78 хувь нь эрэгтэй 22 хувь эмэгтэй байна. Газар өмчлөгч, эзэмшигчдийн 2019-2021 оны хүйсээр ангилсан судалгаатай болсон. 5. Сэлэнгэ аймгийн ГХБХБГ: 2022 оны эхний хагас жилийн байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 201 иргэнд шинээр газар эзэмшүүлж, ашиглуулсан бол 414 иргэнд шинээр газар өмчлүүлсэн байна. Тэдгээрийг насны ангиллаар авч үзвэл 40-с дээш насны 102 иргэн газар эзэмшиж, 152 иргэн газар өмчилсөн бол 18-40 насны 99 иргэн газар эзэмшиж, 262 иргэн газар өмчилсөн байна. Хүйсээр ангилан авч үзвэл эрэгтэй 103 иргэн газар эзэмшиж, 222 иргэн газар өмчилсөн бол, эмэгтэй 98 иргэн газар эзэмшиж, 192 иргэн тус тус газар өмчилсөн байна. 6. Булган аймаг Газрын удирдлагын нэгдсэн системд орж байгаа мэдээллийг нас хүйсээр нь ангилан бүртгэх боломж бүрдсэн. 7. Дундговь аймгийн ГХБХБГ: Аймгийн хэмжээнд газар өмчилсөн 15939 иргэний 52,9 хувь нь эр, 47,1 хувь нь эмэгтэй газар эзэмшсэн 6572 иргэний 64,7 хувь нь эрэгтэй, 35,3 хувь нь эмэгтэй байна. Газрын харилцаа болон барилга хот байгуулалтын чиглэлийн үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөхөд суурь судалгаа, нөхцөл боломж бүрдсэн.

<table>
<tr>
<td>1.3. Салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр, бодлого боловсруулалт, хэрэгжилтэд болон байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг эмэг тэй, эрэгтэй хүмүүсийн бүлгийн оролцоотой хэл элцэн, шийдвэрлэж байх.</td>
<td>1.Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог хангах, тэдний хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
2.Байгууллага, хамт олны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний санал, бодлыг сонссон байна.</td>
<td>ШҮ1: Үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн тоо, тэдний хүйсийн харьцаа;
ШҮ2: Ажлын үр дүн</td>
<td>
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын 2022 оны мэдээ

Тус газрын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ мөн Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны хүйсийн тэнцвэрт байдлын мэдээг хавсралтаар гарган хүргүүллээ.
<table>
<tr><th rowspan="3">№</th><th rowspan="3">Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагын нэр</th><th rowspan="3">Нийт</th><th colspan="2" rowspan="2">Нийт албан хаагчид</th><th colspan="4">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Газар хэлтсийн дарга</th><th colspan="2">Бусад гүйцэтгэх, туслах</th></tr>
<tr><th>Эр</th><th>Эм</th><th>Эр</th><th>Эм</th><th>Эр</th><th>Эм</th></tr>
<tr><td>1</td><td>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар</td><td>80</td><td>34</td><td>46</td><td>8</td><td>2</td><td>26</td><td>44</td></tr>
</table>
<table>
<tr><th rowspan="3">№</th><th rowspan="3">Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагын нэр</th><th rowspan="3">Нийт</th><th colspan="2" rowspan="2">Нийт албан хаагчид</th><th colspan="4">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Газар хэлтсийн дарга</th><th colspan="2">Бусад гүйцэтгэх, туслах</th></tr>
<tr><th>Эр</th><th>Эм</th><th>Эр</th><th>Эм</th><th>Эр</th><th>Эм</th></tr>
<tr><td>1</td><td>Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба</td><td>225</td><td>91</td><td>134</td><td>16</td><td>6</td><td>74</td><td>129</td></tr>
</table>
1.Орхон аймгийн ГХБХБГ: Нийт 19 албан хаагч 40:60 харьцаатай ажиллаж байна.

2.Хөвсгөл аймгийн ГХБХБГ: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны хагас жилийн байдлаар Тус газарт 45 албан хаагч /газрын даамал, мэргэжилтэн, төрийн үйлчилгээний албан хаагчид/ ажиллаж байгаагаас 21 эрэгтэй 24 эмэгтэй албан хаагч байгаа бөгөөд аливаа шийдвэр гаргахад тэгш оролцоог хангаж, саналыг авч тусгаж шийдвэрлэдэг.

3.Баянхонгор аймгийн ГХБХБГ: Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт, Үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комиссын 2021 оны 07 сарын 09-ний өдрийн А/107, А/02, 202, 02/09 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагын хөдөлмөрийн
</td>
</tr>
</table>

			дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн заавар"-ын мөрдлөг болгон ажиллаж байна. 4.Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: 2022 оны эхний хагас жилд албан хаагчдын нас хүйс, албан тушаал, цалингийн талаарх судалгааг нэгдсэн байдлаар гаргасан. Үүний үр дүнд нийт албан хаагчдын 38 хувь нь эрэгтэй, 62 хувь нь эмэгтэй албан хаагч байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад бүх албан хаагчдаас санал авдаг бөгөөд хагас жилийн байдлаар байгууллагын дотоод журмыг батлахад албан хаагчдыг бүрэн хамарсан хурал хийж санал хурааж ажилласан. 5. Булган аймгийн ГХБХБГ: Байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаатай, батлагдсан бүтэц орон тоонд дүн шинжилгээ хийхэд 35 албан хаагчаас 17 эрэгтэй 18 эмэгтэй албан хаагч тус тус ажиллаж байна. 6.Ховд аймгийн ГХБХБГ: Газрын даргын 2022 оны А/12 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталж, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах заалтыг тусгасан. Эхний хагас жилийн байдлаар байгуулсан 4 ажлын хэсэг, зөвлөлийн бүрэлдэхүүний жендэрийн тэгш байдлыг ханган ажилласан. Албан хаагчдын жендерийн талаарх статистик мэдээ, судалгааг төрийн захиргааны албан хаагч, үйлчилгээний албан хаагч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх албан тушаалтан, туслах албан тушаалтан, мөн шагнал урамшуулал, тусламж олгосон албан хаагч, сургалтад хамрагдсан албан хаагч, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн албан хаагч гэсэн үзүүлэлтүүдээр тус тус гаргасан. 7.Төв аймгийн ГХБХБГ: Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.3-д заасны дагуу 10.3-т Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байна. "ГХБХБГазар"-т нийтдээ 47 албан хаагчид ажилладгаас эрэгтэй 21, эмэгтэй 26 албан хаагчид байна. 8.Дундговь аймгийн ГХБХБГ: Албан хаагчдын дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Тус байгууллага нийт 28 албан хаагчтайгаас 12 эрэгтэй 16 эмэгтэй албан хаагч ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын дотоод журмыг албан хаагчдаар хэлэлцүүлэн шинэчлэн боловсруулж байгууллагын даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар батлуулсан.

<table>
<tr>
<td>1.4. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.</td>
<td>1.Жендэрийн эрх тэгш, ил тод байдал хангагдсан байна.</td>
<td>ШҮ1: Сургалтын хөтөлбөрт тусгагдсан заалт хэрэгжсэн байх;
ШҮ2: Хэрэгжилтийн хувь</td>
<td>Жендэрийн тэгш байдлын мэдлэг олгох ажлын хүрээнд Геодезийн тусгай зөвшөөрлийн эрхтэй-237, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа, эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй-147, нийт 384 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Газрын даргын 2022 оны тушаалаар хяналт, шинжилгээ-үнэлгээ хийхээр удирдамж боловсруулж батлуулсан. Хэрэгжилтийг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцагдсан.

Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрхтэй ААН-ийн захирлуудын хүйсийн харьцааг харууллаа.

<table>
<tr><td rowspan="2">№</td><td colspan="2">1
Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн хүйсийн харьцаа</td><td colspan="2">2
Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн хүйсийн харьцаа</td><td colspan="2">3
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүйсийн харьцаа</td><td colspan="2">4
Кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн хүйсийн харьцаа</td></tr>
<tr><td>Эр</td><td>Эм</td><td>Эр</td><td>Эм</td><td>Эр</td><td>Эм</td><td>Эр</td><td>Эм</td></tr>
<tr><td>2020</td><td>52</td><td>14</td><td>6</td><td>5</td><td>25</td><td>17</td><td>4</td><td>3</td></tr>
<tr><td>2021</td><td>57</td><td>13</td><td>6</td><td>5</td><td>30</td><td>15</td><td>5</td><td>1</td></tr>
<tr><td>2022</td><td>36</td><td>11</td><td>4</td><td>2</td><td>19</td><td>13</td><td>1</td><td>-</td></tr>
</table>

1. Орхон аймагт “Их нэмүүн констракшн” ХХК, “Эрд кадастр” ХХК, “Алсын зураглал” ХХК, “Глобус” ХХК, “Гранд Амар” ХХК, “Богдын өндөр сүрвэй” ХХК, “Эхлэх цэг хангай” ХХК, “Инженер геодези” ХХК, “Эко натур” ХХК, “Говь эко” ХХК, “Эс Эм стар геойд” ХХК, “Ланд овнер” ХХК, “Дөрвөн талст экологи” ХХК, “Геоботаник” ХХК, “Акро мандал” ХХК-нууд Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил хийж байгаад бөгөөд 30 эрэгтэй, 15 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 15 аж ахуйн нэгжээс 562 захиалгат чанарын хянан баталгааны ажил, нэг төлөвлөгөөт хянан баталгааны ажил ирүүлснээс 465 иргэн аж ахуйн нэгжийн захиалгат хянан баталгааны тайланг баталгаажуулан 20 тайланг хянан буцааж, 47 тайланг хянан зөвшөөрч, 30 тайлан баталгаажуулахаар хүлээгдэж байна.

2. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: Орон нутгийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг барилга угсралт засварын 3 аж ахуйн нэгж байгууллагын 19 инженер техникийн ажилчдын судалгааг Барилгын нэгдсэн мэдээллийн цахим системээр авч, нас хүйсээр нь</td>
</tr>
</table>

			ангилан судалгааг хийгээд байна. 8 эмэгтэй, 11 эрэгтэй инженер техникийн ажилчид бүртгэгдсэн байна. 2. Орон нутгийн хэмжээнд салбарын чиглэлийн инженер техникийн ажилчдад АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран 2022 оны III улиралд сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 3. Хөвсгөл аймгийн ГХБХБГазар: 2022 оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд барилгын Барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад тус газраас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах талаар албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн байна. 4. Төв аймгийн ГХБХБГ: Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн 4 байгууллага байгаагаас эмэгтэй 5 ажилтан, эрэгтэй 25 албан хаагчид ажиллаж байна. Барилгын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг 20 аж ахуй нэгжийн ажилчдын 10 хувь нь эмэгтэй 90 хувь нь эрэгтэй албан хаагчид байна. 5.Сүхбаатар аймгийн ГХБХБГ: Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлөөс Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян-2022 нээлтийн арга хэмжээг Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 04-р сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Алтансүх, Мэргэжилтэн Б.Бат-Оргил нар хамрагдсан. 6.Дундговь аймгийн ГХБХБГ: Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 байгууллага байгаагаас эмэгтэй 3 ажилтан, эрэгтэй 1 албан хаагч ажиллаж байна. Тус аймгийн барилгын салбарын инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын судалгааг гаргахад нийт 58 ажилчдын 25 хувь нь эмэгтэй 75 хувь эрэгтэй ажилтан албан хаагчид байна.

1.5. Жендэрийн Үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад байгууллага, мэргэжлийн байгууллага, ТББ-ын удирдлагуудыг хамруулах арга хэмжээг авах.	1.Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон сонирхсон албан хаагчдын энэ талын мэдлэг дээшилсэн байна. 2.Сургагч багш нартай болсон байна.	ШҮ1: Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	1. Орхон аймгийн ГХБХБГ: Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх” сэдэвт сургалтад байгууллагын 2 эрэгтэй 5 эмэгтэй албан хаагчийг хамруулсан. 2. Сүхбаатар аймгийн ГХБХБГ: Мерит төслөөс хэрэгжүүлж буй “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлалыг орон нутгийн захиргааны байгууллагад нэвтрүүлэх жишиг төсөл”-ийг орон нутагт хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна. Дээрх арга хэмжээний хүрээнд “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдэвт 5 цагийн цахим сургалтад байгууллагын 18 албан хаагч хамрагдсан. 3. Баянхонгор аймгийн ГХБХБГ: Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, жендерийн үндэсний хорооны салбар зөвлөлийн хамтарсан “Жендерийн мэдрэмжтэй төрийн алба” сургалтад Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр мэргэжилтэн Б.Номинчулуун хамрагдсан. 4. Говь-Алтай аймгийн ГХБХБГ: 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд Хүний эрхийн Үндэсний комиссоос Монгол улсад мэргэшсэн төрийн албыг бий болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулах, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын шинээр баталсан хууль хэрэглээ ба жендэр, хүний эрхийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх сургалтад ГХБХБГ-ын дарга Д.Гаадамба хамрагдсан. 5. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газраас явуулсан “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх хөтөлбөрт Жендерийн эрх тэгш, ил тод байдлын тухай сэдвээр лекц орсон бөгөөд байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан. 6. Дундговь аймгийн ГХБХБГ: Албан хаагчдын ажлын байран дээрх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Жендэрийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн сумдын Газрын даамлуудын сургалтын үеэр дээрх сургалтыг дахин зохион байгуулсан. Нийт 2 удаагийн сургалтад нийт 28 албан хаагч хамрагдсан. Англи улсад төвтэй Олон улсын Мокоро байгууллагатай хамтарсан Хүн төвтэй байгаль хамгаалал байгууллагын хэрэгжүүлж буй "Газар эдэлбэрийн баталгаат байдал" төсөл болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар хамтран 2022 оны 10 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд "Газар зохион байгуулалт ба олон нийтийн оролцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулж байна. Сургалтад Нийслэл, дүүрэг, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнүүд хамрагдсан. Энэхүү сургалтад иргэдийн оролцоотой, нээлттэй, шинэлэг оролцооны аргуудыг болон жендерийн мэдрэмжтэй газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт хийх чиглэлээр хийгдэж байгаагаараа онцлог.

1.6. Байгууллагын удирдах ажилтнууд болон албан хаагчдыг жендэр, хүний эрхийг хангах чиглэлээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.	1.Ажилтнууд жендэрийн эрх тэгш байдал, түүнийг хэрэгжүүлэх талаар мэдлэг, аргачлал эзэмшиж, хэрэглэх чадамжтай болсон байна.	ШҮ1: Сургалтын болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо:	1. Жендерийн мэдрэмжтэй газар зохион байгуулалт сэдвээр Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүдэд 5 дугаар сарын 25, 27-ны өдрүүдэд, ГЗБГЗЗГ-ын ССМХ, ГЗБХ, ЗУХАГ-ын албан хаагчдыг 5 дугаар сарын 30-ны өдөр "Жендэрийн мэдрэмжтэй газар зохион байгуулалтын төлөвлөлт" сэдвийн хүрээнд Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төслийн жендерийн мэргэжилтэн Ц.Энхмаа хичээл заасан. Нийт 60 орчим хүнд танхимын сургалтад хамрагдсан. 2. Сүхбаатар аймгийн ГХБХБГазар: "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт" сэдэвт 5 цагийн цахим сургалтад байгууллагын удирдах ажилтнууд болон 18 албан хаагч хамрагдсан. Мөн салбарын бодлого, төлөвлөлт хэрэгжилтэд жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг хэрхэн тусгах болон хөдөлмөрийн дотоод журмыг жендерийн мэдрэмжтэй боловсруулсан туршлага танилцуулах сургалтад 2022 оны 06 сарын 02-ны өдөр холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан. 3. Баянхонгор аймгийн ГХБХБГ: Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн амын хөгжил, хүүхэд, залуучууд, гэр бүл жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, салбар хорооны нарийн бичгийн дарга В.Наранчимэгийг урьж, "Жендэрийн үндсэн ойлголт, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт" сэдвээр 2022 оны 04 сарын 31-ний өдрийн 15 цагт зохион байгуулсан. Сургалтаар Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, Жендэрийн тэгш байдал, Төрийн албанд эрүүл нийцэмжтэй орчин бүрдүүлэх, Ажил ар гэрийн амьдралын тэнцвэр сэдвүүдийн хүрээнд 8 эрэгтэй, 9 эмэгтэй албан хаагчид идэвхтэй хамрагдаж, харилцан ярилцсан. хэдэн албан хаагч оролцсон. 4. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: Байгууллагын удирдах болон албан хаагчид Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай сургалтад хагас жилийн байдлаар 1 удаагийн сургалтад хамрагдсан байна. АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран 2022 оны III улиралд албан хаагчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 5. Булган аймаг 2022 оны хагас жилийн байдлаар сургагч багшийн сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй бөгөөд албан хаагчдаас сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. 6. Дундговь аймгийн ГХБХБГ: Аймгийн ЗДТГ-аас удирдах албан тушаалтнуудад "Жендэрийн тухай ойлголт" сэдвээр сургалт зохион байгуулсан ба уг сургалтад тус байгууллагаас 4 албан хаагч хамрагдсан. Мөн Хүний эрхийн үндэсний комиссоос НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төсөл, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-тай хамтран жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдыг орон нутгийн түвшинд шалгаруулсан. Дээрх сонгон шалгаруулалтад 19 аймгийн 170 гаруй байгууллагын 1800 гаруй албан хаагч хамрагдаж аймаг бүрд гурван салбараар жендэрийн мэдрэмжтэй 29 удирдагчийг шалгаруулсан ба тус байгууллагын дарга Э.Чагнаадорж шалгарсан.

2.1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах чиглэлээр байгууллагын албан хаагчдын дунд санал асуулга явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, холбогдох арга хэмжээг авч байх, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх.	1.Санал асуулга-23 2.Ажилтнуудаа шинжилгээ, оношилгоо, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. 3.Байгууллагын албан хаагчдын нас, хүйс, албан тушаал, цалин, чөлөө, нийгмийн баталгааны чиглэлээрх мэдээлэл бүхий судалгааг харьцуулан гаргаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	ШҮ1: Асуулга явуулсан байгууллагын тоо; ШҮ2: Шинжилгээ, оношилгоонд хамруулсан албан хаагчдын тоо; ШҮ3: Судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн;	1. Орхон аймгийн ГХБХБГ: Орхон аймгийн “Медипас” эмнэлэгт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үзлэгт 4 эрэгтэй, 11 эмэгтэй нийт 15 албан хаагчийг хамруулсан. 2. Ховд аймгийн ГХБХБГ: Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд нийт 20 албан хаагчийг хамруулсан. Албан хаагчдын 2022 оны хагас жилийн жендерийн талаарх статистик мэдээ, судалгааг /албан хаагчдын нас, хүйс, албан тушаал, цалин, чөлөө, нийгмийн баталгааны/ гарган хавсаргав гаргаж хавсаргав. 3. Говь-Алтай аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар Ажилтнуудаа шинжилгээ, оношилгоо, эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй болно. 2022 оны 3-р улиралд багтаан нийт ажилчдыг үзлэг оношилгоонд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. 4. Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: 2022 оны эхний хагас жилийн байдлаар 36 */19 эмэгтэй, 17 эрэгтэй/* албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр газрын харилцаа болон барилга хот байгуулалтын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үүнд: • Газрын дарга /Ахлах түшмэл/ - 1 */1 эрэгтэй/* • Хэлтсийн дарга /Дэс түшмэл/ - 2 */2 эрэгтэй/* • Ахлах мэргэжилтэн /Дэс түшмэл/ - 2 */1 эрэгтэй, 1 эмэгтэй/* • Мэргэжилтэн /Дэс түшмэл/ - 9 */5 эрэгтэй, 4 эмэгтэй/* • Газрын даамал /Дэс түшмэл/ - 18 */6 эрэгтэй, 12 эмэгтэй/* • Төрийн үйлчилгээний гүйцэтгэх ажилтан - 2 */2 эмэгтэй/* • Төрийн үйлчилгээний туслах ажилтан- 2 */2 эрэгтэй/* Нийт албан хаагчдын 27.8 хувь буюу 10 */3 эрэгтэй, 7 эмэгтэй/* нь 18-30 насны албан хаагч, 44.4 хувь буюу 16 */9 эрэгтэй, 7 эмэгтэй/* нь 31-40 насны албан хаагч, 27.8 хувь буюу 10 */5 эрэгтэй, 5 эмэгтэй/* нь 41-50 насны албан хаагч байна. Тайлант хугацаанд нийт 16 /7 эрэгтэй, 9 эмэгтэй/ албан хаагч эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, шинжилгээ, оношилгоо хийлгэсэн байна. Дээрх албан хаагчдад байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу 7 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгосон. 5. Баянхонгор аймгийн ГХБХБГ: Эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын наслалтын зөрүүг бууруулах чиглэлээр бие бялдар, дасгал хөдөлгөөнтэй эрүүл амьдрах орчныг бүрдүүлж, Долоо хоног бүрийн Лхагва гариг 16-20 цагийн хооронд Чандмань-Баянхонгор ХХК-ын зааланд тоглож хэвшсэн. 6. Хөвсгөл аймгийн ГХБХБГ: Аймгийн нэгдсэн эмнэлэгт байгууллагын албан хаагчдыг үзлэг оношилогоонд хамруулахаар судалгааг гаргаж албан тоотоор илгээсэн бөгөөд одоогоор хариу ирээгүй байна. 7. Булган аймгийн ГХБХБГ: Нийт 33 ажилтантай бөгөөд 60-40 насны 4 албан хаагч, 40-30 насны 17 албан хаагч, 30-25 насны 12 албан хаагч ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг 2022

			аяны хүрээнд бүх албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах захиалга хүргүүлээд байна. 8. Төв аймгийн ГХБХБГ: 2021 оны 12 сард байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх ажлыг зохион байгуулж IT лабораторид эмнэлэгт нийт 38 албан хаагчийг 940 000 төгрөгийн зардлыг гарган албан хаагчдыг бүрэн хамруулсан. ЭМСайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэмжих төвөөр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийлгүүлэхээр байгууллагын албан хаагчдын судалгааг гаргаж хүргүүлсэн. 9. Дундговь аймгийн ГХБХБГ: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.2.6, албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт зорилт болгон тусгасан. Албан хаагчдыг жил бүр Улаанбаатар хотод эмнэлгүүдтэй гэрээ байгуулж эрүүл мэндийн үзлэгт үе шаттайгаар хамруулж хэвшсэн. 2021 оны 11 дүгээр сард “Гурван гал” эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан. 2022 оны эрүүл мэндийн үзлэгийг 4 дүгээр улиралд зохион байгуулна. Агентлагийн нийт 85 албан хаагчдыг ХСҮТ-ийн хавдрын эрт илрүүлэгд 16 төрлийн үзлэг, оношилгоо хийлгэсэн. Үүнээс эмэгтэй-58, эрэгтэй-27 албан хаагч байлаа.
2.2. Иргэн ба албан хаагчийг ажилд авах болон хүний нөөцийн асуудлаар ялгаваралгүйгээр шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, шударга, хувь хүнтэй зөвшилцлийн замаар шийдвэрлэх нөлөөллийг бий болгох арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх.	1.Хүний нөөцийн талаар гарсан шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна. 2.Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албанд жендэрийн тэгш байдлын баталгааг хангасан байна.	ШҮ1: Шийдвэр хууль тогтоомжийн дагуу гарсан байх; ШҮ2: Хүний нөөцийн талаарх шийдвэртэй холбогдон гарсан гомдол, саналын тоо;	1.Орхон аймгийн ГХБХБГ: Хүний нөөцийн талаар 15 тушаал шийдвэр боловсруулж, албажуулсан байна. Тушаал, шийдвэртэй холбоотой гомдол, санал гараагүй болно. Зэрэг дэв болон ур чадварын нэмэгдлийн талаар 7 эрэгтэй, 8 эмэгтэй ажилтан албан хаагчтай холбоотой хүйсийн тэнцвэрт байдлыг хангасан тушаал гарсан байна. 2. Ховд аймгийн ГХБХБГ: Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу 2 албан хаагчийг байгууллага хооронд, 3 албан хаагчийг байгууллага дотроо шилжүүлэн ажиллуулж, 4 албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн 1 орон тоог тусгай шалгалтаар нөхсөн. Ахлах мэргэжилтний албан тушаалд дэвшүүлэн томилсон 1 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулан, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/2136 тоот дүгнэлтийг үндэслэн томилох шийдвэр гаргасан. Албан хаагчдын 2022 оны хагас жилийн жендерийн талаарх статистик мэдээ, судалгааг гарган хавсаргав. Хүний нөөцийн талаарх шийдвэртэй холбогдон гарсан гомдол, санал гараагүй. 3. Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар: 2022 оны эхний хагас жилийн байдлаар тус байгууллага нь 3 хэлтсийн 18 мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан, 17 сумын 18 газрын даамал нийт 36 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр газрын харилцаа болон барилга хот байгуулалтын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын даргын 1 удаагийн тушаалаар эмэгтэй албан хаагчдын тоо 19 болж нэмэгдсэнээр байгууллагын албан хаагчдын хүйсийн харьцаа 52.7:47.3 */эмэгтэй албан хаагчдын тоо 19, эрэгтэй албан хаагчдын тоо 17/* болсон байна.

			Мөн тайлант хугацаанд байгууллагын дотоод журамд заасны дагуу */7.5.3. Албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад болон гэр бүл болох, шинээр хүүхэдтэй болоход 100.000 /зуун мянга/ хүртэл төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгана./* шинээр хүүхэдтэй болсон 1 эмэгтэй албан хаагчид 100.000 төгрөгийн тэтгэмж олгож, */7.4.1.3 Албан хаагчийн гэр бүлийн гишүүн /төрүүлсэн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд/ нас барсан тохиолдолд 250.000 /хоёр зуун тавин мянган/ төгрөг нэг удаа/* төрүүлсэн эцэг эх нь нас барсан 1 эрэгтэй, 1 эмэгтэй албан хаагчид тус бүр 250.000 төгрөгийн тусламжийг үзүүлсэн. "Төрийн албаны тухай хууль", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын дагуу Газрын даргын 2022 оны "Албан тушаалын ангилал, зэрэглэлийг өөрчилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/02 тушаалаар 1 эрэгтэй, 1 эмэгтэй албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр нэмэгдүүлэн олгож байна. "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинд үндэслэн нийт 21 албан хаагчид зэрэг дэв олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/95 тоот захирамжаар 9 эрэгтэй, 6 эмэгтэй албан хаагчид зэрэг дэвийг ахиулан, 3 эрэгтэй, 3 эмэгтэй албан хаагчид зэрэг дэвийг шинээр тус тус олгуулж ажилласан. Мөн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинд үндэслэн Газрын даргын 2022 оны "Цалингийн шатлал ахиулах тухай" Б/01 дүгээр тушаалаар 5 эрэгтэй, 9 эмэгтэй албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлж Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолд заасан хэмжээгээр албан хаагчдын цалин урамшууллыг олгож байна. 4. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: Хагас жилийн байдлаар 1 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд 1 албан хаагч Төрийн албан хаагчийг дэвшүүлэн томилох журмын дагуу томилогдон ажиллаж байна. 5. Хөвсгөл аймгийн ГХБХБГ: 2022 оны эхний хагас жилд 3 сул орон тоог нөхүүлэхээр Төрийн албаны зөвлөлд захиалгаа хүргүүлсэн бөгөөд Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу Төрийн албаны шалгалтад орж тэнцсэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор томилогдсон албан хаагчдыг хуулийн дагуу тухайн албан тушаалд томилуулан ажиллаж байна. 6. Булган аймгийн ГХБХБГ: Төрийн албаны тухай хуулийн дагуу хүний нөөцийн томилгоог Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран хуулийн хүрээнд ил тод нээлтэйгээр сонгон шалгаруулалтыг зарладаг. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2 эмэгтэй албан хаагч сонгон шалгаруулалтын дагуу томилогдсон. 7. Төв аймгийн ГХБХБГ: Төрийн албаны тухай хуулийн дагуу хүний нөөцийн томилгоог Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран хуулийн хүрээнд ил тод нээлтэйгээр сонгон шалгаруулалтыг зарладаг. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 4 эрэгтэй албан хаагч

			сонгон шалгаруулалтын дагуу томилогдсон. Төрийн албаны салбар зөвлөлд 2 албан тушаалын сул орон тооны захиалгыг хүргүүлэн ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1. дэх заалтын дагуу 1 эрэгтэй, 1 эмэгтэй албан хаагчийг шилжүүлэн ажилласан. Мөн энэ онд нийт 25 албан хаагч зэрэг дэвийн нэмэгдэл авснаас эмэгтэй 16 албан хаагч 9 эрэгтэй албан хаагч байна. 8. Дундговь аймгийн ГХБХБГ: Тус байгууллагад ажиллагсдын харьцаа 55:45 байгаа нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.3-т заасан Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах гэсэн заалтыг бүрэн хангаж байна. Тус байгууллагын хэмжээнд албан хаагчийг ажилд авах болон хүний нөөцийн асуудлаар аливаа нэгэн ялгавартай шийдвэр гарч байгаагүй болно. a) Төрийн жинхэнэ албанд томилогдсон 5 албан хаагчийг Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн томилсон. b) Төрийн жинхэнэ албаны тусгай шалгалт өгөх 5 албан хаагчид Ёс зүйн болон сахилгын зөрчилын талаарх дүгнэлт гарган өгсөн.
2.3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдөх, урьдчилан сэргийлэх	1.Хөдөлмөрийн харилцаа тэгш зарчмаар явагдсан байна. 2.Ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн болон бусад дарамт шахалт гарахгүй байна. 3.Гарсан зөрчлийг үл тэвчих орчин бүрдсэн байна.	ШҮ1: Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх; ШҮ2.Зохион байгуулсан ажлын тоо.	1. Орхон аймгийн ГХБХБГ: Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Орхон аймгийн ГХБХБГ нь байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2022 оны оны 01 сарын 17-ны А/03 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Хөдөлмөрийн дотоод журмын 1.4.9, 7.20, 12.3 дахь заалтуудад дээрх заалтыг тусгаж өгсөн. 2. Ховд аймгийн ГХБХБГ: Газрын даргын 2022 оны А/12 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар холбогдох заалтыг тусгаж, Google линкээр ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуулгыг авч ажиллаж байна. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол ирээгүй. 3. Говь-Алтай аймгийн хэмжээнд хөдөлмөрийн дотоод журмыг 2022 оны 04 дүгээр сарын 13-ы өдрийн А/11 дүгээр тушаалаар батлан мөрдлөг болгон ажиллаж байна. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол 2022 оны хагас жилийн байдлаар ирээгүй байна. 4. Баянхонгор аймгийн ГХБХБГ: Ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах санал хүсэлтийн хайрцаг ажиллуулсан. Ажлын байран дахь бэлгийн дарамт гэж юу вэ? мэдээллийн зурагт хуудсыг байршуулсан. 5. Говьсүмбэр аймгийн ГХБХБГ: Байгууллагын дотоод журмыг Газрын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд тус журмын 8.3 дахь заалтад хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө

мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулан бэлгийн дарамт болон бусад шахалт дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх.			чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасан. 12.2.3 дахь заалтад бэлгийн дарамт үзүүлэхгүй байх гэж заасан байдаг. Байгууллагын дотоод журмыг ил тод байршуулан, албан хаагчдад танилцуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. 6. Булган Хөвсгөл аймгийн ГХБХБГ: Хөдөлмөрийн дотоод журмаа шинэчлэн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамт, хэрвээ гарсан тохиолдолд санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх,бэлгийн дарамт болон бусад шахалт дарамтыг үл тэвчих талаар тусгаж өгсөн. Одоогоор үүнтэй холбоотой ямар нэгэн санал гомдол ирээгүй байна. 7. Төв аймгийн ГХБХБГ: Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн 2022 оны А/27 дугаар тушаалаар шинэчлэн батлсан. Дотоод журамд жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдлөг болгон ажиллаж байна. 8. Дундговь аймгийн ГХБХБГ: Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын дотоод журмыг албан хаагчдаар хэлэлцүүлэн шинэчлэн боловсруулж байгууллагын даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар батлуулсан. Ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусган мөрдөж байна. Тус газраас Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, ажлын байрны бэлгийн дарамтыг үл тэвчих орчинг бүрдүүлэхэд холбогдох хуульд заасан эрх, үүргийг тус газрын нийт удирдах албан тушаалтнуудад чиглэсэн сургалт, зөвлөмжийг өгсөн.

ЖЕНДЭРИЙН ОРОН ТООНЫ БУС ДЭД САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.МАНДАХЗУЛ

ЖЕНДЭРИЙН ОРОН ТООНЫ БУС ДЭД САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.ГАНЦЭЦЭГ